БУЛГАН  АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

## 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** БУА-2020/101/СТА-ТШЗ

---

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.bulgan@audit.mn<br>Булган аймаг<br>2020 он | Булган аймаг дахь Төрийн аудитын газрын<br>тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр<br>Утас:90900910  Цахим хаяг: Ankhbayard@audit.gov.mn<br>Аудитын менежер: Ж.Энхцоодол<br>Утас: 99057478  Цахим хаяг:Enhtsoodolj@audit.gov.mn<br>Гэрээт аудитор: П.Эрдэнэзул<br>Утас:99812414  Цахим хаяг: Erdenezulp@audit.gov.m |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ
2. Аудитын тайлан

2.1 Оршил ........ 5

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ........ 5

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ........ 6

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ........ 6

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ........ 7

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ........ 7

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ........ 7

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ........ 8

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал…..9

2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .... 9

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ........ 9

2.11. Шилэн дансны мэдээлэл ........ 10

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга ........ 10

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ........ 10

3 Менежментийн захидал
11

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан
12

# 1 Аудитын гэрчилгээ

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2020.02.20 № 62

танай ______________-ны №__________________т

ХЯЛГАНАТ ТОСГОН ДАХЬ СУМ
ДУНДЫН ОЙН АНГИЙН ДАРГА
М.НЯМЖАРГАЛ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 -д заасны дагуу Хялганат тосгон дахь Сум дундын ойн ангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Хялганат тосгон дахь Сум дундын ойн ангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт,мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж , Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хялганат тосгон дахь Сум дундын ойн ангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

006020113

**Үүрэг, хариуцлага**

Хялганат тосгон дахь Сум дундын ойн анги нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн *8 дугаар зүйлийн* дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

# 2 Аудитын тайлан

## 2.1. Оршил

Хялганат тосгон дахь Сум дундын ойн ангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга М.Нямжаргалд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хялганат тосгон дахь Сум дундын ойн ангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хялганат тосгон дахь Сум дундын ойн ангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.02.18-наас 2020.02.20–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Булган аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор П.Эрдэнэзул хариуцаж хэрэгжүүлэв.

Булган аймгийн Хялганат тосгоны Ойн анги 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь төрийн аудитын газарт 2020.01.24-ны өдрийн 04 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Хялганат тосгон дахь Сум дундын ойн ангийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Хялганат тосгон дахь Сум дундын ойн анги нь Байгаль дэлхий уул ус, ан амьтан, ой, ургамлаа хайрлан хамгаалах сэтгэлийг хүн бүхэнд төлөвшүүлэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Хялганат тосгон дахь Сум дундын ойн ангийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байхгүй.

### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд (нийцсэн) байна.

Хялганат тосгон дахь Сум дундын ойн ангийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд Шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Хялганат тосгон дахь Сум дундын ойн ангийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Си ти эс” программ хангамж ашигладаг байна.

дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд (Бага) гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт (Үр нөлөөтэй) гэж үзлээ.

### 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 16 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 12 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

### 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр *Нийт зардал*-ын *2* хувиар сонгов.

Хялганат тосгон дахь Сум дундын ойн ангийн нийт зардал-г материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Байгууллагын нийт болон цэвэр хөрөнгөөс материаллаг түвшинг тогтооход материаллаг байдлын түвшин өндөр гарч байгаа тул нийт зардлын 2 хувиар материаллаг байдлын түвшинг тогтоох нь зүйтэй гэж үзлээ. - холбоотой юм.

Хялганат тосгон дахь Сум дундын ойн ангийн 2019 оны *Нийт зардал* 2,162.11 мянган төгрөг бөгөөд түүний *2* хувь болох *2,162.11* мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг *2* хувиар тооцсон нь 2 холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

### 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 1 чиглэлээр аудитын 16 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 0 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 16 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 0 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

| № | Шийдэл | Тоо | Дүн | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Зөвлөмж өгсөн | 0 | 0.00 | |
| 2 | Төлбөрийн акт тогтоосон | 0 | 0.00 | |
| 3 | Албан шаардлага өгсөн | 0 | 0.00 | |
| 4 | Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн | 0 | 0.00 | |
| 5 | Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн | 0 | 0.00 | |
| | Дүн | 0 | 0.00 | |

**2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв.

**2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Байхгүй

**2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Хялганат тосгон дахь Сум дундын ойн ангийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2019 онд 53005.0 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 38907.0 мянган төгрөг буюу 73.4 хувьтай байгаа нь шалтгаалжээ.

**2.11. Шилэн дансны мэдээлэл**

Хялганат тосгон дахь Сум дундын ойн ангийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

**2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмжгүй.

**2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Хялганат тосгон дахь Сум дундын ойн ангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хялганат тосгон дахь Сум дундын ойн ангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН:

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР Ж.ЭНХЦООДОЛ

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

БЭЛТГЭСЭН:

ГЭРЭЭТ АУДИТОР П.ЭРДЭНЭЗУЛ

## 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

# 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **13.432.140,15** | **7.700.565,15** |
| **33** | **АВЛАГА** | 10.561.350,00 | 4.893.850,00 |
| **335** | **Бусад авлага** | 10.561.350,00 | 4.893.850,00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 10.561.350,00 | 4.893.850,00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 2.870.790,15 | 2.806.715,15 |
| **354** | **Хангамжийн материал** | 2.870.790,15 | 2.806.715,15 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 743.450,00 | 598.250,00 |
| 35420 | Аж ахуйн материал | 2.127.340,15 | 2.208.465,15 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **119.011.103,64** | **107.443.407,76** |
| **37** | **УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ** | - | - |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 119.011.103,64 | 107.443.407,76 |
| 391 | Газар | | |
| **392** | **Биет хөрөнгө** | 78.524.353,64 | 67.100.957,56 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 7.386.639,30 | 7.386.639,30 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | - | (1.586.029,68) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 50.691.319,48 | 50.691.319,48 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (15.663.580,26) | (20.871.392,82) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 23.804.532,46 | 23.804.532,46 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (12.991.444,72) | (15.702.347,20) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 8.262.652,00 | 8.262.652,00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (3.381.974,57) | (4.138.866,89) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 44.824.751,22 | 47.154.751,22 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (24.408.541,27) | (27.900.300,31) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 40.486.750,00 | 40.342.450,20 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 40.847.500,00 | 40.847.500,00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | (360.750,00) | (505.049,80) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **132.443.243,79** | **115.143.972,91** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **132.443.243,79** | **115.143.972,91** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 132.443.243,79 | 115.143.972,91 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 49.022.000,00 | 49.022.000,00 |
| 51101 | Өмч: - төрийн | | |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 76.184.757,95 | 58.885.487,07 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 76.184.757,95 | 76.184.757,95 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (17.299.270,88) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 7.236.485,84 | 7.236.485,84 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **132.443.243,79** | **115.143.972,91** |

## 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

### САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **147.207.837,15** | **90.806.400,00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **113.304.437,15** | **57.116.900,00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 113.304.437,15 | 57.116.900,00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 82.454.437,15 | 43.391.900,00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 18.019.000,00 | 25.421.300,00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 18.218.750,00 | 7.662.200,00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдэлээс санхүүжих | - | 7.978.400,00 |
| 1200044 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | | |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 46.216.687,15 | 2.330.000,00 |
| 120005 | Түрээсийн орлого | | |
| 120009 | Бусад орлого | 30.850.000,00 | 13.725.000,00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **33.903.400,00** | **33.689.500,00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | - | 33.689.500,00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 33.689.500,00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 33.903.400,00 | - |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 33.903.400,00 | - |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **109.471.537,21** | **108.105.670,88** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **109.471.537,21** | **108.105.670,88** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 101.343.699,78 | 93.239.693,88 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 27.607.483,50 | 36.707.200,00 |
| 210101 | Үндсэн цалин | 26.469.881,00 | 32.565.300,00 |
| 210102 | Нэмэгдэл | 1.137.602,50 | 4.141.900,00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 5.219.364,07 | 4.575.948,00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 4.611.811,07 | 3.307.525,00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 155.100,00 | 320.600,00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 124.500,00 | 256.400,00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 28.200,00 | 64.100,00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 299.753,00 | 627.323,00 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | | |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 6.188.400,00 | 6.425.700,00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 132.000,00 | 369.300,00 |
| 210302 | Түлш, халаалт | 5.700.000,00 | 5.700.000,00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 356.400,00 | 356.400,00 |
| 210304 | Байрны түрээс | | |
| 210305 | Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/ | | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3.361.550,00 | 4.147.475,00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210401 | Бичиг хэрэг | 388.700,00 | 681.800,00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2.201.400,00 | 2.614.175,00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 283.250,00 | 630.000,00 |
| 210404 | Ном, хэвлэл | - | 221.500,00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 195.100,00 | - |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 293.100,00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | - | 550.000,00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 550.000,00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6.023.165,00 | 4.010.900,00 |
| 210604 | Урсгал засвар | 6.023.165,00 | 4.010.900,00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 452.300,00 | 1.668.900,00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 452.300,00 | 1.668.900,00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 483.638,00 | 1.255.875,00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 344.438,00 | 1.063.875,00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 48.000,00 | 48.000,00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 54.100,00 | 45.000,00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 37.100,00 | 55.000,00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | - | 44.000,00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 52.007.799,21 | 33.897.695,88 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 45.938.812,00 | 19.752.500,00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 247.500,00 | 247.500,00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 5.821.487,21 | 13.897.695,88 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 8.127.837,43 | 14.865.977,00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 768.000,00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | - | 768.000,00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 7.902.837,43 | 14.097.977,00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 7.902.837,43 | 14.097.977,00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 225.000,00 | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 225.000,00 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **37.736.299,94** | **(17.299.270,88)** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | - | - |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 737.289,49 | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 737.289,49 | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (737.289,49) | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **36.999.010,45** | **(17.299.270,88)** |

## 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **100.991.150,00** | **88.476.400,00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **67.087.750,00** | **54.786.900,00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 67.087.750,00 | 54.786.900,00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 36.237.750,00 | 41.061.900,00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 18.019.000,00 | 25.421.300,00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 18.218.750,00 | 7.662.200,00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдэлээс санхүүжих | - | 7.978.400,00 |
| 120009 | Бусад орлого | 30.850.000,00 | 13.725.000,00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **33.903.400,00** | **33.689.500,00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | - | 33.689.500,00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 33.689.500,00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 33.903.400,00 | - |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 33.903.400,00 | - |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **97.851.250,00** | **88.476.400,00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **97.851.250,00** | **88.476.400,00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **89.723.412,57** | **73.610.423,00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 29.294.619,00 | 36.707.200,00 |
| 210101 | Үндсэн цалин | 20.927.100,00 | 32.565.300,00 |
| 210102 | Нэмэгдэл | 2.734.900,00 | 4.141.900,00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 5.632.619,00 | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 3.532.228,57 | 4.575.948,00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 2.585.828,57 | 3.307.525,00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 236.600,00 | 320.600,00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 189.300,00 | 256.400,00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 47.300,00 | 64.100,00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 473.200,00 | 627.323,00 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | | |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 6.188.400,00 | 6.425.700,00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 132.000,00 | 369.300,00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210302 | Түлш, халаалт | 5.700.000,00 | 5.700.000,00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 356.400,00 | 356.400,00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3.509.600,00 | 4.002.275,00 |
| 210401 | Бичиг хэрэг | 336.600,00 | 536.600,00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2.201.400,00 | 2.614.175,00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 721.500,00 | 630.000,00 |
| 210404 | Ном, хэвлэл | - | 221.500,00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 250.100,00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | 357.300,00 | 550.000,00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 357.300,00 | 550.000,00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 7.523.165,00 | 4.010.900,00 |
| 210604 | Урсгал засвар | 7.523.165,00 | 4.010.900,00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 452.300,00 | 1.668.900,00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 452.300,00 | 1.668.900,00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1.793.300,00 | 1.337.000,00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1.629.700,00 | 1.145.000,00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 48.000,00 | 48.000,00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 61.900,00 | 45.000,00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 37.700,00 | 55.000,00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 16.000,00 | 44.000,00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 37.072.500,00 | 14.332.500,00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 36.825.000,00 | 14.085.000,00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 247.500,00 | 247.500,00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **8.127.837,43** | **14.865.977,00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 768.000,00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | - | 768.000,00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 7.902.837,43 | 14.097.977,00 |
| 213302 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө | | |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 7.902.837,43 | 14.097.977,00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 225.000,00 | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 225.000,00 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | 3.139.900,00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **3.139.900,00** | **-** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **3.139.900,00** | **-** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 3.139.900,00 | - |
| 222001 | Тоног төхөөрөмж | 1.249.900,00 | - |
| 223001 | Бусад хөрөнгө | 1.890.000,00 | - |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(3.139.900,00)** | **-** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

### ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 8.896.000,00 | - | 39.185.747,50 | 48.081.747,50 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **8.896.000,00** | **-** | **39.185.747,50** | 48.081.747,50 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | 7.236.485,84 | - | 7.236.485,84 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 40.126.000,00 | - | - | 40.126.000,00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 36.990.010,45 | 36.990.010,45 |
| C08 | **2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **49.022.000,00** | **7.236.485,84** | **76.184.757,95** | 132.443.243,79 |
| D01 | **2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **49.022.000,00** | **7.236.485,84** | **76.184.757,95** | 132.443.243,79 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **49.022.000,00** | **7.236.485,84** | **76.184.757,95** | 132.443.243,79 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (17.299.270,88) | (17.299.270,88) |
| D09 | **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **49.022.000,00** | **7.236.485,84** | **58.885.487,07** | 115.143.972,91 |

## 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

**/төгрөгөөр/**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 0,00 | 92863312,57 | 53005000,00 | 52991223,00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 0,00 | 89723412,57 | 53005000,00 | 52991223,00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 0,00 | 89723412,57 | 52237000,00 | 52223223,00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 0,00 | 29294619,00 | 32055000,00 | 32055000,00 |
| 210101 | Үндсэн цалин | 0,00 | 20927100,00 | 27913100,00 | 27913100,00 |
| 210102 | Нэмэгдэл | 0,00 | 2734900,00 | 4141900,00 | 4141900,00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | | | |
| 210104 | Урамшуулал | | | | |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 0,00 | 5632619,00 | 0,00 | 0,00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 0,00 | 3532228,57 | 4008200,00 | 3994423,00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 0,00 | 2585828,57 | 2726000,00 | 2726000,00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 0,00 | 236600,00 | 320600,00 | 320600,00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 0,00 | 189300,00 | 256400,00 | 256400,00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 0,00 | 47300,00 | 64100,00 | 64100,00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 0,00 | 473200,00 | 641100,00 | 627323,00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 0,00 | 6188400,00 | 6425700,00 | 6425700,00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 0,00 | 132000,00 | 369300,00 | 369300,00 |
| 210302 | Түлш, халаалт | 0,00 | 5700000,00 | 5700000,00 | 5700000,00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 0,00 | 356400,00 | 356400,00 | 356400,00 |
| 210304 | Байрны түрээс | | | | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 0,00 | 3509600,00 | 3733800,00 | 3733800,00 |
| 210401 | Бичиг хэрэг | 0,00 | 336600,00 | 536600,00 | 536600,00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 0,00 | 2201400,00 | 2345700,00 | 2345700,00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | - | 721.500,00 | 630.000,00 | 630.000,00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210404 | Ном, хэвлэл | - | - | 221.500,00 | 221.500,00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | | | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 250.100,00 | - | - |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | | | | |
| **2105** | **Нормативт зардал** | - | 357.300,00 | 550.000,00 | 550.000,00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | | | |
| 210502 | Хоол, хүнс | | | | |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 357.300,00 | 550.000,00 | 550.000,00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 7.523.165,00 | 2.510.900,00 | 2.510.900,00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | | | |
| 210602 | Тавилга | | | | |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | | | |
| 210604 | Урсгал засвар | - | 7.523.165,00 | 2.510.900,00 | 2.510.900,00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | - | 452.300,00 | 1.368.900,00 | 1.368.900,00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | | | |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 452.300,00 | 1.368.900,00 | 1.368.900,00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | - | 1.793.300,00 | 1.337.000,00 | 1.337.000,00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 1.629.700,00 | 1.145.000,00 | 1.145.000,00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 48.000,00 | 48.000,00 | 48.000,00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | - | 61.900,00 | 45.000,00 | 45.000,00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | - | 37.700,00 | 55.000,00 | 55.000,00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | - | 16.000,00 | 44.000,00 | 44.000,00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | - | 37.072.500,00 | 247.500,00 | 247.500,00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 36.825.000,00 | - | - |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 247.500,00 | 247.500,00 | 247.500,00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | - | 768.000,00 | 768.000,00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | - | 768.000,00 | 768.000,00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | | | | |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | | | | |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | - | - | 768.000,00 | 768.000,00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **3.139.900,00** | **-** | **-** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 3.139.900,00 | - | - |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 1.249.900,00 | - | - |
| 223001 | Бусад хөрөнгө | - | 1.890.000,00 | - | - |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | - | 36.237.750,00 | - | 67.089.200,00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | - | - | - | 33.689.500,00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | - | - | - | 33.689.500,00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | - | 36.237.750,00 | - | 33.399.700,00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 18.019.000,00 | - | 25.421.300,00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 18.218.750,00 | - | - |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | - | - | - | 7.978.400,00 |